



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 11/22.

Мөрөн сум

□ Ц.Болорцэцэгийг Хүнс, ЖДҮ, хоршооны
асуудал хариуцсан мэргэжилтний үүрэгт
ажлаас чөлөөлөх тухай □

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 46 дүгээр зүйлийн 46.2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ц.Болорцэцэг нь Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчоор дэвшин ажиллах болсон тул 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Хүнс, жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогч Ц.Болорцэцэгийн ажлыг хүлээн авах, хүлээлгэн өгөх комиссыг дор дурдсанаар байгуулсугай

Комиссын дарга:	Г.Дашмаа	Төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүдэд:	Н.Энхмягмар	Нийгмийн даатгалын Улсын байцаагч
	Ж.Алтанцэцэг	Татварын Улсын байцаагч
	Г.Хишигбаатар	Хууль эрх зүйн мэргэжилтэн
	А.Энхтөр	Аж ахуйн нярав

3.Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Эрдэнэцэцэгийн ажлыг шинээр томилогдсон Ц.Болорцэцэгт хүлээлгэн өгөх ажлыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн ажлын 5 хоногт багтаан дуусгахыг Комиссын дарга Г.Дашмаа-д үүрэг болгосугай.

4.Д.Эрдэнэцэцэгийн ажлыг шинээр томилогдсон Ц.Болорцэцэгт хүлээлгэн өгөхдөө баримт бичиг,техник хэрэгсэл, эд хогшлыг нэг бүрчлэн акт үйлдэн хүлээлцэхийг комиссын нийт гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ

